

**ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар нь /цаашид "Талууд" гэх/ найрамдалт харилцаагаа бэхжүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх хоёр талын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хоёр талын бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэх, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр дараахь зүйлийг харилцан тохиролцов:

**1 дүгээр зүйл
Хамтын ажиллагааны хүрээ**

Талууд тус тусын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийг баримтлан энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын бүрэн эрхийн хүрээнд дараахь гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

1. олон улсын террорист үйл ажиллагаа;
2. хар тамхи, мансууруулах эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөлөх бодис болон химийн анхдагч зүйлсийн хууль бус худалдаа;
3. хууль бусаар барааг хилээр нэвтрүүлэх;
4. мөнгө угаах;
5. мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх;
6. паспорт, виз болон бусад баримт бичгийг хуурамчаар үйлдэх;
7. галт зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, цөмийн материал болон цацраг идэвхт бодисыг хууль бусаар хилээр нэвтрүүлэх;
8. зохион байгуулалттайгаар хүнийг хууль бусаар хил нэвтрүүлж тээвэрлэх, тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
9. залилан;
10. компьютерийн гэмт хэрэг;
11. үндэстэн дамнасан бусад гэмт хэрэг.

**2 дугаар зүйл
Мэдээлэл солилцох**

Талууд тус тусын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрх бүхий байгууллагууд хоорондоо дараахь мэдээллийг харилцан солилцоно. Үүнд:

1. энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар;
2. аль нэг талын иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэргийн хохирогч болсон талаар;

- 3.шүүх ажиллагаанаас зугтсан сэжигтэн, яллагдагч болон ял эдэлж байгаад оргосон этгээдийн талаар;
- 4.тодорхой шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шинэ арга барил, ажиллагааны талаар;
- 5.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлийн хууль тогтоомж;
- 6.Талуудын сонирхож байгаа бусад асуудал.

3 дугаар зүйл **Туршлага солилцох**

Талуудын эрх бүхий байгууллагууд дараахь чиглэлээр туршлага солилцоно. Үүнд:

- 1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх болон мөрдөн шалгах ажиллагаа;
- 2.хүн амыг удирдан зохицуулах, нийгмийн хяналтын тогтолцоо;
- 3.галт зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, хорт бодис, цөмийн материал, цацраг идэвхт бодис болон бусад аюултай хорт бодист тавих хяналт;
- 4.хилээр орох, гарах асуудал болон гадаадын иргэдийн зохицуулалт;
- 5.замын хөдөлгөөн, төмөр зам, боомт, иргэний агаарын болон агаарын тээврийн аюулгүй байдлын талаарх зохицуулалт;
- 6.компьютерийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажлын техник арга барил болон хариу арга хэмжээ;
- 7.гал түймрээс урьдчилан сэргийлэх;
- 8.цагдаагийн байгууллагын эрх зүйн зохицуулалт;
- 9.боловсрол, сургалтыг хөгжүүлэх замаар цагдаагийн байгууллагуудыг бэхжүүлэх;
- 10.хуурай газрын болон усан хилийн зохицуулалт.

4 дүгээр зүйл **Интерполын шугамаар хамтран ажиллах**

Талууд Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Интерполын үндэсний төв товчоодын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

5 дугаар зүйл **Хамтын ажиллагааны хэлбэр**

1. Талуудын эрх бүхий байгууллагууд тус тусын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хамтран ажиллаж, энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд

заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр өөрсдийн эрх мэдлийн хүрээнд тус тусын нутаг дэвсгэрт гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг болон гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, баривчлах, мөрдөн шалгах ажлыг зохион байгуулж, тухайн этгээдийн хэн болох, хэргийн нотлох баримт болон хэргийн талаар мэдэгдэн эдгээр этгээдийг нөгөө Талд шилжүүлэн өгөх арга хэмжээ авна.

2. Талуудын эрх бүхий байгууллагууд өөрийн нутаг дэвсгэрт байгаа нөгөө улсын иргэд, байгууллагын аюулгүй байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд тэдгээрийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг нөгөө талдаа мэдэгдэнэ.

3. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Талууд дараахь байгууллагуудаар дамжуулан хамтран ажиллана:

- Монгол Улсын талаас Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Утас: (976) 11-325225, факс: (976) 11-325225/
- БНХАУ-ын талаас Нийгмийг аюулаас хамгаалах яамны Олон улсын хамтын ажиллагааны газар /Утас 0086-10-66263329, факс 0086-10-58186022/

Талууд хамтын ажиллагаандаа англи хэлийг хэрэглэнэ.

6 дугаар зүйл Нууцлалыг хадгалах

Аль нэг тал өөрийн өгсөн мэдээлэл, баримт бичгийнхээ нууцлалыг хадгалах хүсэлт гаргасан тохиолдолд нөгөө Тал нууцлалыг хадгалахад шаардагдах бүхий л арга хэмжээг авна.

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хүлээн авсан мэдээлэл, бичиг баримт болон техникийн арга барилыг ирүүлсэн талын бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр гуравдагч талд шилжүүлж үл болно.

7 дугаар зүйл Хүсэлт биелүүлэхээс татгалзах

Хүсэлтийг хүлээн авч биелүүлэх нь тухайн улсын бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдал, эсхүл олон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл нөгөө талын ирүүлсэн хүсэлтийг биелүүлэхээс бүрэн, эсхүл хэсэгчлэн татгалзаж болно.

Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлтийг биелүүлэхээс бүрэн, эсхүл хэсэгчлэн татгалзсан тухай шалтгааныг хүсэлт гаргасан Талд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

**8 дугаар зүйл
Зардал**

Талууд урьдчилан өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрийн дагуу солилцох хоёр талын төлөөлөгчдийн олон улсын тээврийн зардлыг илгээгч тал, хүлээн авагч талын нутаг дэвсгэрт байх зардлыг хүлээн авч буй Тал хариуцна.

**9 дүгээр зүйл
Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай**

Талууд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, цаашдын хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцох уулзалтыг Бээжин, Улаанбаатар хотуудад ээлжлэн зохион байгуулна.

**10 дугаар зүйл
Олон улсын бусад гэрээтэй уялдах**

Энэхүү Хэлэлцээр нь Талуудын гарын үсэг зурсан, эсхүл нэгдэн орсон олон улсын гэрээнээс үүдэн гарах бусад эрх, үүргийг хөндөхгүй.

**11 дүгээр зүйл
Нэмэлт, өөрчлөлт оруулах**

Талууд харилцан зөвшилцсөнөөр энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

**12 дугаар зүйл
Хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаа, хэл**

Энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд аль нэг тал нөгөө талдаа Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас гурван сарын өмнө уг Хэлэлцээрийг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдээгүй тохиолдолд энэхүү Хэлэлцээр тав, таван жилээр аяндаа сунгагдана.

Энэхүү Хэлэлцээрийг монгол, хятад, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, Улаанбаатар хотноо 2011 оны 7 дугаар сарын 7-ны өдөр гарын үсэг зурав. Эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахтай холбоотой маргаан гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

